



АЛТАНБУЛАГ
ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ

2015 оны 10 сарын 07 өдөр

Дугаар А/77


Улаанбаатар хот

“Алтанбулаг” чөлөөт бүсэд тамхи болон тамхи орлуулагч бүтээгдэхүүн худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамж, гэрчилгээний төлбөр тогтоох тухай

Монгол улсын “Чөлөөт бүсийн тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.7.11 дэх заалт, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх заалт, “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийн 4 дүгээр зүйл, 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, “Чөлөөт бүсэд тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтанбулаг чөлөөт бүс”-эд тамхи болон тамхи орлуулагч бүтээгдэхүүн худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хураамж, гэрчилгээний төлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Холбогдох хууль журмын дагуу улсын тэмдэгтийн хураамж, гэрчилгээний төлбөр тооцоог хийж ажиллахыг Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтсийн дарга /О.Мөнхмаа/-д үүрэг болгосугай.
3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий менежер /Х.Балжмаа/-т даалгасугай.

ЗАХИРАГЧИЙН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



П.ТОГТОХБАЯР

"Алтанбулаг" чөлөөт бүсийн Захирагчийн
2018 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн
А/77 тоот захирамжийн хавсралт

ТЭМДЭГТИЙН ХУРААМЖ, ГЭРЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

"Алтанбулаг чөлөөт бүс"-эд тамхи болон тамхи орлуулагч бүтээгдэхүүн худалдах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь "Улсын тэмдэгтийн хураамжийн тухай" хуульд заасны дагуу дараах хураамжийг төлөх үүрэгтэй. Үүнд:

1. Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгоход 250 000 төгрөг, сунгах, сэргээхэд тус тус 250 000 төгрөг
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний үнэт цаас, эх бэлтгэл, хэвлэлтийн үйлчилгээ үзүүлсний төлбөр 10.000 төгрөг.

---o0o---